

Ерөнхий боловсролын салбарын төсвийн хэрэгжилт, зохицуулалт, санхүүжилт хариуцсан мэргэжилтэн / Улаанбаатар /, Оюунбилэг Ууганчимэг

2025 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
			1	2	3	4	5
1.1. Ерөнхий боловсролын сургуулийн санхүү, төсвийн төрийн бодлого, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх							
1	Боловсролын төсвийн бодлого, батлагдсан хөтөлбөр, арга хэмжээний гүйцэтгэл, холбогдох дүрэм, журмын хэрэгжилтийг үндэсний түвшинд зохион байгуулах, төсвийн гүйцэтгэлийг нэгдсэн удирдлага, мэргэжил, арга зүйгээр хангах, чиглүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	2024 онд ерөнхий боловсролын төрийн өмчийн 685, төрийн бус өмчийн 167 сургуулиудад тухай бүр мэргэжил аргазүйгээр хангаж ажилласан	Боловсролын төсөв санхүүгийн, үйл ажиллагаа сайжирсан байна.	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 39, 53 дугаар "Хувьсах зардлын хэмжээ, итгэлцүүр, журам батлах тухай" тогтоолын дагуу 2024-2025 оны хичээлийн жилийн статистик хүүхдийн тоогоор ерөнхий боловсролын төрийн өмчийн 690 сургуулийн 2025 оны хувьсах төсвийг тооцож Боловсролын ерөнхий газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн А/01 дугаар тушаалаар баталсан. 2025 оны баталсан төсвийн	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					хуваарийг Аймаг, нийслэлийн боловсролын газруудад хуулийн хугацаанд хүргүүлсэн. 2025 оноос шинээр хэрэгжиж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийн бүрэн хангаж ажиллаж байна. Үүнд: Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 254 дүгээр "Хүүхдийн хоолны түүхий эдийн зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай" тогтоолын дагуу Ерөнхий боловсролын сургуулийн 1-5 ангийн хүүхдийн үдийн хоол 2500 төгрөг, дотуур байрны хүүхдийн хоол 6000-6300 төгрөгөөр тооцож 2025 оны төсвийг баталж, санхүүжүүлж байна. Монгол улсын их хурлын 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 54 дүгээр "Монгол улсын 2025 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" тогтоолын дагуу боловсролын салбарын		
--	--	--	--	--	--	--	--

					байгууллагуудад 2025 оны баталсан төсвийн хүрээнд ажиллахыг чиглэл болгон ажиллаж байна. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/170 дугаар "Заавар батлах тухай" тушаал шинэчлэгдэж, Боловсролын сайдын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/279 дугаар "Заавар шинэчлэн батлах тухай" тушаалаар шинэчилсэн зааврыг нэгжүүдэд хүргүүлж ажиллаа. 2025 оны эхний хагас жилд төрийн өмчийн 690 ерөнхий боловсролын сургуульд 1,217,834.2 сая төгрөг, төрийн бус өмчийн 166 ерөнхий боловсролын сургуульд 25,504.2 сая төгрөгийн хувьсах төсөв тооцож олгохоор баталсан. Хавсралт: 1 файл		
2	Төрийн болон төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургуулийн гүйцэтгэл, үр дүнгийн санхүүжилтийн	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	2024 онд гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийг төрийн өмчийн 685 байгууллага, төрийн бус өмчийн 176	Монгол Улсын төрийн болон төрийн бус өмчийн бүх ерөнхий боловсролын сургуульд үр дүнд суурилсан	Төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн гүйцэтгэл, үр дүнд суурилсан санхүүжилтийг бүрэн	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар,	100%

	системийг улам төгөлдөржүүлж, үргэлжлүүлэн хэрэгжүүлэх		байгууллагад олгосон.	санхүүжилтийн систем бүрэн хэрэгжсэн байна.	хэрэгжүүлж байна. МУЗГ-ын 2024 оны 238 дугаар тогтоолын дагуу 2025 оны 1 дүгээр сараас эхлэн төрийн албан хаагчийн цалин нэмэгдсэнтэй холбогдуулан Засгийн газрын 2024 оны 39, 53 дугаар "Хувьсах зардлын хэмжээ, итгэлцүүр, журам батлах тухай" тогтоолд өөрчлөлт оруулах санал, төслийг Боловсролын яаманд хүргүүлсэн. Ерөнхий боловсролын сургуулиудын цалин, нэмэгдэл хөлсний санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэн сар бүр санхүүжилтийг тооцож олгож байна. Мөн төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургуулийн хувьсах төсвийг сар бүрийн хүүхдийн тооны ирцийн гүйцэтгэлээр тооцож санхүүжүүлж байна. Засгийн газрын 2024 оны 25 дугаар тогтоолын "Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын	7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	
--	---	--	----------------------------------	--	---	--	--

					гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам"-ын дагуу 2025 оны 1, 2 дугаар улирлын багшийн үр дүнгийн урамшууллын 35,4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тооцож олгосон. Үдийн хоол, дотуур байрны хүүхдийн хоолны санхүүжилтийг хүүхдийн тооны гүйцэтгэл, сар бүрийн төсвийн гүйцэтгэлд үндэслэн дараагийн сарын санхүүжилтийг тооцож олгож байна. Хавсралт: 1 файл		
3	Боловсролын салбарын төсвийн гүйцэтгэл, үр дүнг Төсвийн ерөнхийлөн захирагч, Боловсролын сайдын өмнө хариуцан ажиллах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	ЗГ-ын 2024 оны 39, 53 дугаар тогтоолын дагуу төрийн өмчийн ЕБС санхүүжилтийг хүүхдийн тоотой уялдуулан тооцож сар бүрийн 10-ны дотор, төрийн бус өмчийн сургуулийн санхүүжилтийг аймгийн БГ, НБГ, дүүргийн боловсролын хэлтсээс ирүүлсэн хүүхдийн тооны	Ерөнхий боловсролын сургуулийн санхүүжилтийг олгож, сургалтын байгууллагуудын санхүү, төсвийн хэвийн үйл ажиллагааг хангаж ажилласан байна.	Төрийн болон орон нутгийн өмчийн 690 сургууль, төрийн бус өмчийн 166 сургуулийн гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийг, төрийн өмчийн сургуульд сар бүрийн 10-ны дотор, төрийн бус өмчийн сургуульд сарын бүрийн 25-ны дотор санхүүжүүлж байна. Хүүхдийн тооны гүйцэтгэлээр үдийн хоол, дотуур байрны	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

			ирцийн гүйцэтгэлээр сар бүрийн 25-ны дотор хувьсах зардлыг санхүүжүүлж байна.		хүүхдийн хоолны санхүүжилтийг олгож байна. 2025 оны 1-6 дугаар сард төрийн өмчийн 690 сургуульд өссөн дүнгээр 1217,8 тэрбум төгрөг, төрийн бус өмчийн 165 сургуульд өссөн дүнгээр 14,0 тэрбум төгрөгний хувьсах зардлын санхүүжилт олгосон. 2025 оны 1,2 улирлын багшийн гүйцэтгэлийн үр дүнгийн урамшуулалд төрийн өмчийн 669 сургуульд 35,4 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна. Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн 200-гаас бага хүүхэдтэй 100 сургуулийн 2025 оны төсвийг орон тооны нормативаар гүйцэтгэлээр тооцож 2025 оны төсвийг дахин тооцож баталсан. Мөн төрийн өмчийн Ерөнхий боловсролын 141 сургуульд Писа-2025 боловсролын чанарын үнэлгээтэй холбоотойгоор ерөнхий боловсролын зарим сургуулиудад	
--	--	--	---	--	--	--

					олгох тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын нэмэлт 2,8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг Боловсролын сайдын 2025 оны тушаалын дагуу санхүүжүүлсэн. Мөн БС-ын 2025 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн А/219 дүгээр тушаалаар нийт ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны нөхөн хангалтын зардалд 29,8 тэрбум төгрөг баталсанг санхүүжүүлсэн. Хавсралт: 1 файл		
4	Ерөнхий боловсролын сургуулийн төсвийн хэрэгжилт, зохицуулалт, санхүүжилтийг зохион байгуулах, үр дүнг хариуцан тайлагнах.	Санхүү, төсвийн хэвийн үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	Төрийн өмчийн 685 сургууль, төрийн бус өмчийн 176 сургуульд санхүүжилтийг олгож ажилласан.	Ерөнхий боловсролын сургуулиудын санхүүжилтийг олгож, байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг хангаж ажилласан байна	Төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн сар бүрийн санхүүжилтийг гүйцэтгэлээр нь тооцож, нэгжээс ирүүлсэн өр төлбөрийн судалгаа, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогын санал, орон нутгийн байгууллагаас ирүүлсэн орлогын саналыг нэгжүүдээс сарын бүрийн 25-ны дотор хүлээн авч фискал программд	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					дараа сарын 10-ны дотор шивж оруулан санхүүжилтийг олгож байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаж байна. 2025 оны 1-6 дугаар сарын байдлаар төрийн өмчийн 690 сургуульд улсын төсвөөс 1,217.8 тэрбум төгрөг, бүх сургуулийн 51,3 тэрбум төгрөгний орлогын саналыг төсөв шивж оруулан санхүүжүүлсэн. Төрийн бус өмчийн 166 сургуульд 14,0 тэрбум төгрөгний хувьсах зардлын санхүүжилтийг хүүхдийн тооны ирцийн гүйцэтгэлээр санхүүжилт олгосон. Солонгос дахь Монгол ерөнхий боловсролын төрийн бус сургууль 2025 оны 1 улирлын санхүүжилт 29,0 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Сар бүрийн олгосон санхүүжилтийн хэтрэлт хэмнэлтийн тайлбарыг Боловсролын яаманд тайлагнаж байна. Санхүүгийн динамик программд сар бүрийн төсвийн төлөвлөгөөг	
--	--	--	--	--	---	--

					маягтын дагуу боловсруулж дамжуулж байна. Хавсралт: 2 файл		
5	Төрийн болон төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургуулийн төсвийг төлөвлөх, хуваарилах, санхүүжүүлэх, тайланг нэгтгэх ажлыг холбогдох хууль, журмын хүрээнд зохион байгуулах /БШУЯ: 3.12, 3.12.1, БЕГ:1.18.1/	Санхүү, төсвийн хэвийн үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	Төрийн өмчийн 685 сургууль, төрийн бус өмчийн 176 сургуульд санхүүжилтийг олгож ажилласан.	Ерөнхий боловсролын сургуулиудын санхүүжилтийг олгож, байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг хангаж ажилласан байна.	МУЗасгийн газрын 2024 оны 39, 53 дугаар тогтоолын дагуу төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулиудын төсвийг 2024-2025 оны хичээлийн жилийн статистик хүүхдийн тоогоор хувьсах төсвийг тооцож төсөвлөж, санхүүжилтийг гүйцэтгэлээр тооцож олгож байна. 2024-2025 оны хичээлийн жил төрийн болон төрийн бус өмчийн 879 ерөнхий боловсролын сургуульд 797905 хүүхэд суралцаж байгаа бөгөөд 2025 онд нийт хувьсах төсөв 1,974,888.4 сая төгрөг, үндсэн, туслах үйл ажиллагааны орлого 78,1 тэрбум төгрөгийн санал батлагдсан. Шинээр нийслэлд 94, 184, 172, 166, орон нутагт Өмнөговь аймагт 6-р сургуулиуд ашиглалтад орж 2025	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					оны төсвийг тооцоходоо хүүхдийн тооны шилжилт хөдөлгөөнийг үндэслэж төсвийг тооцож, санхүүжилтийг олгож, байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаж байна. Шинээр ашиглалтад орж байгаа сургуулиудад Засгийн газрын 2024 оны 39, 53 дугаар тогтоолын дагуу ажиллах, орон тооны норматив баримталж ажиллахыг чиглэл болгон хүргүүлж байна.		
6	Насантуршийн суралцахуйн төвийн гүйцэтгэл, үр дүнгийн санхүүжилтийн системийг улам төгөлдөржүүлж, үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	Санхүү, төсвийн хэвийн үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	2024 онд НТСТ-ийн 29 байгууллагад гүйцэтгэл үр дүнгийн санхүүжилт олгосон.	НТСТ-ийн үр дүнд суурилсан санхүүжилтийн систем бүрэн хэрэгжсэн байна.	2025 онд Насантуршийн суралцахуйн төвийн төсвийг орон тооны гүйцэтгэлээр тооцож нийт 30 төвд төсөв батлан, санхүүжилтийг сар бүр олгож байна. Багахангай дүүрэгт шинээр Насантуршийн суралцахуйн төв ашиглалтад орж санхүүжилт авч эхэлсэн. Сар бүр Насантуршийн суралцахуйн төвөөс ирүүлсэн орлогын саналыг хүлээн авч фискал программд	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					оруулж байна. Санхүүгийн динамик программд сар бүрийн төсвийн төлөвлөгөөг маягтын дагуу боловсруулж дамжуулж байна. 2025 онд улсын төсвөөс 12,3 тэрбум төгрөгийн төсөв батлагдсан, 2025 оны 1-6 дугаар сард 6,2 тэрбум төгрөгийн улсын төсвөөс санхүүжилт олгосон, орлогын саналд 10-н Насантуршийн суралцахуйн төвөөс 321,2 сая төгрөгийн орлогыг төсөвт оруулсан, 1-6 дугаар сард 6,2 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна. Насантуршийн суралцахуйн төвийн захирлууд болон санхүүгийн албан хаагчдад 2025 оны төсөв санхүүтэй холбоотой цахим мэдээллийг тухай бүр хүрүүлж байсан. Боловсролын сайд, Гэр бүл, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2024 оны А/136, А/80, А/69 дугаар тушаалаар	
--	--	--	--	--	---	--

					"Насан туршийн суралцахуйн төвийн албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт", Боловсролын сайд, Сангийн сайдын А/135, А/68 дугаар тушаалаар "Орон тооны хязгаарын жишиг норматив батлах тухай" тушаалууд батлагдаж 2026 оны эхнээс хэрэгжүүлэхээр төлөвлөн тооцоо судалгааг боловсруулан ажиллаж байна. Хавсралт: 2 файл		
--	--	--	--	--	--	--	--

3.1. Ерөнхий боловсролын салбарын төсвийн хэрэгжилт, зохицуулалт, санхүүжилтийг зохион байгуулж, мэргэжил, арга зүйгээр хангах

7	Боловсролын сургалтын байгууллагуудын батлагдсан төсвийн хуваарийг аймаг, нийслэлийн боловсролын газруудад өөрчлөлт орсон тухай бүр хүргүүлэх, төсөвт өөрчлөлт орсон тайлбар, тодруулга болон төсөв санхүүтэй холбоотой мэдээллээр мэргэжил арга зүйгээр төсвийн	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	Монгол улсын Засгийн газрын 39, 53 -р тогтоолын дагуу төрийн өмчийн 685 сургууль, төрийн бус өмчийн 177 сургуулийн 2024 оны төсвийн сар улирлын хуваарийг боловсруулан БЕГ-ын даргын 2024 оны А/07, А/78 дугаар тушаалаар тус тус батлуулан аймаг, нийслэл, дүүргийн төсвийн	Боловсролын салбарын батлагдсан төсвийн хуваарь, төсөвтэй холбоотой нэмэлт тодруулга, тайлбарыг боловсролын байгууллагуудад өөрчлөлт орсон тухай бүр хүргүүлж ажилласан байна	Монгол улсын Засгийн газрын 2024 оны 39, 53 дугаар тогтоолын дагуу төрийн өмчийн 690 сургуулийн 2025 оны хувьсах төсвийг тооцон баталж нэгж байгууллагуудад хүргүүлсэн. Төсвийн хуваарьтай холбоотой нэмэлт тодруулга, тайлбарыг тухай бүр аймгийн мэргэжилтэн, төсвийн шууд захирагч, нягтлан бодогч нарт тус бүрт утсаар	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
---	--	---------------------------------	--	---	--	--	------

	мэргэжилтэнгүүдийг хангах		мэргэжилтнүүдэд хүргүүлэн ажилласан		мэдээлэл өгч ажиллаа. 2025 оны 1-6 сарын нэмэлт орлого, түрээсийн сурах бичиг, үндсэн, туслах үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөний саналыг хүлээн авч, төсөвт тусгаж оруулсан. 2025 оны 4 дүгээр сард аймаг, нийслэлийн боловсролын газрын төсөв санхүүгийн мэргэжилтэнгүүдтэй цахим уулзалтыг зохион байгуулж багш ажилчдын ээлжийн амралт цалинг тооцох, батлагдсан төсвийн хүрээнд ажиллах, өр төлбөр үүсгэхгүй байх, орон тооны нормативын дагуу ажиллах талаар чиглэл мэдээллийг хүргүүлж ажилласан. Аймаг, нийслэлийн БГ-ын төсвийн мэргэжилтэнгүүдэд ЕБС-ийн төсөв санхүүтэй холбоотой мэдээлэл, дотуур байрны багш, албан хаагчдад дотуур байрны төсөв санхүүтэй холбоотой, насантуршийн суралцахуйн төвийн		
--	---------------------------	--	-------------------------------------	--	---	--	--

					захирал, санхүүгийн албан хаагчдад насан туршийн төсөв санхүүтэй холбоотой мэдээллийг тухай бүр хүргүүлж ажилласан. Мөн ховд аймаг, төв аймаг, өмнөговь аймгийн боловсролын салбарын удирдах, санхүүгийн 100 гаруй албан хаагчдад төсөв санхүүтэй холбоотой танилцуулга мэдээлэл өгсөн. Хавсралт: 4 файл		
8	Ерөнхий боловсролын салбарын төсвийн хүрээний мэдэгдлийн санал боловсруулахад анхан, дунд шатны байгууллагыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	2024 онд боловсролын салбарын төсвийн төслийн цахим системд ЗГ-ын 2024 оны 39 дүгээр тогтоолын дагуу шинэчлэлийг хийж, шинэчилсэн цахим төсвийн төслийн сургалтыг Аймаг, нийслэлийн боловсролын газрын мэргэжилтэнгүүд, сургууль цэцэрлэгийн төсөв санхүүгийн албан хаагчдад цахим сургалтыг зохион байгуулсан.	Аймгийн Боловсролын газар, дүүргийн Боловсролын хэлтсийн санхүү, төсвийн мэргэжилтэнгүүдэд мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан байна	2025 оны төсвийн төсөл, батлагдсан төсвийн талаар нэгж байгууллага болон аймгийн мэргэжилтэнгүүдэд мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажилласан. Ерөнхий боловсролын сургуулийн 2026 оны төсвийн төслийг боловсролын мэдээллийн нэгдсэн цахим систем www.esis.edu.mn -ийг ашиглан цахимаар авах ажлын бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар	100%

					Хавсралт: 1 файл		
9	Ерөнхий боловсролын салбарын төсвийн төсөл, төсвийн төсөөллийг боловсруулахад анхан, дунд шатны байгууллагыг нэгдсэн бодлого, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	Төрийн өмчийн 681 сургууль, төрийн бус өмчийн 177 сургуулийн 2025 оны төсвийн төсвийн төсөл нэгтгэн боловсруулж БЯ-нд хүргүүлсэн.	Аймгийн боловсролын газар, Нийслэл, дүүргийн боловсролын хэлтсийн санхүү, төсвийн мэргэжилтнүүдийг тухай бүр мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан байна.	Төрийн өмчийн 690 ерөнхий боловсролын сургууль, төрийн бус өмчийн 189 ерөнхий боловсролын сургуулийн 2026 оны төсвийн төслийг боловсролын мэдээллийн цахим төсөв системээр авах ажлын систем хөгжүүлэх маягыг боловсруулж БМТТ-д хүргүүлсэн. Төсвийн төслийг ЗГ-ын 39, 53 дугаар тогтоолд өөрчлөлт орох төслийн дагуу боловсруулж хүргүүлсэн. Тэтгэвэр, тэтгэмжтэй холбоотой маягыг хуучин авдаг маягтаар хүлээн авахаар Боловсролын газруудад хүргүүлсэн. Хавсралт: 1 файл	6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар	100%
10	МУЗГ-ын 2024 оны 53 дугаар тогтоолын дагуу тооцсон боловсролын салбарын байгууллага бүрийн хувьсах төсвийн гүйцэтгэлд үүссэн өрийн мэдээнд тооцоо судалгаа хийж, батлагдсан төсвийн	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	2024 оны 1-12 дугаар сарын байдлаар цалин, нэмэгдэл хөлсөнд өр төлбөр үүсч байгаа сургуулиудын төсвийн гүйцэтгэлд хяналт тавьж зардал хүрэхгүй байгаа	Боловсролын салбарын байгууллагуудын төсвийн гүйцэтгэл, өрийн мэдээнд дүн шинжилгээ хийж, батлагдсан төсвийн хүрээнд, өр төлбөр, авлага үүсгэхгүй ажилласан байна	2025 оны 1-6 сарын байдлаар өр төлбөр үүсч байгаа сургуулиудын тооцоо судалгаанд хяналт тавьж хүүхдийн тооны гүйцэтгэлээр үдийн хоол, дотуур байрны хоолны санхүүжилтийг бүрэн олгосон. 2025	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар,	100%

	хүрээнд өр авлага үүсгэхгүй ажиллах		сургуулиудын төсвийн хуваарьт тухай бүр өөрчлөлт оруулж ажилласан.		оны батлагдсан төсвийн хүрээнд өр төлбөргүй, ажиллахыг аймаг, нийслэлийн мэргэжилтэнгүүдэд мэдэгдэж ажиллаа. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, сангийн сайдын хамтарсан 2018 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн А/024/11 дугаар "Орон тооны жишиг норматив батлах тухай" тушаалаар төрийн өмчийн бүх сургуулиудын орон тооны норматив баримтлан ажиллаж байна. 2025 оны 6 дугаар сард багш, ажилчдын ээлжийн амралт цалинг тооцох, үдийн цай, дотуур байрны хоолны өр төлбөр, дотуур байрны албан хаагчдын ээлжийн амралтын цалинг тооцох маяг хүснэгтийг боловсруулж 21 аймаг, 9 дүүргийн боловсролын газарт хүргүүлсэн. Ирүүлсэн тооцоо судалгааг нэг бүрчлэн хяналж тооцож байна. 2025 оны 1-6 дугаар сард	11-р сар, 12-р сар	
--	--	--	---	--	--	-----------------------	--

					улсын төсвөөс 1,217,834.2 сая төгрөг, оны эхний үлдэгдлээс 197,661.7 сая төгрөгийн мөнгөн хөрөнгө зарцуулах эрхийг нээхээр ажиллаж байна. 2025 оны 1, 2 улиралд багшийн үр дүнгийн урамшуулалд 35,2 тэрбум төгрөг санхүүжүүлэхээр тооцоолсон. Засгийн газрын 234 дүгээр тогтоолын 1.3 дахь заалтад "Ерөнхий боловсролын сургуулийн ачааллыг бууруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх талаар" авах арга хэмжээний хүрээнд 2024-2025 оны хичээлийн жилд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өмчлөлийн нийт 37 барилгыг түрээслэн сургалтын үйл ажиллагаа явуулж байна. 2025 оны 1-6 дугаар сард нийт 5,312.9 сая төгрөг батлан түрээсийн гэрээний дагуу санхүүжилтийг сар бүр олгож улсын хэмжээнд төрийн өмчийн 690		
--	--	--	--	--	--	--	--

					ерөнхий боловсролын сургуулийг өр төлбөргүй ажиллахаар тооцоо судалгааг хийж ажилласан. Мөн Ерөнхий боловсролын салбарын 2025 оны төсөв, ХБГ тооцоо судалгааг ЗГ-ын 39, 53 дугаар тогтоол, тогтоолын өөрчлөлт орох төслийн дагуу төрийн өмчийн 690, төрийн бус өмчийн 166 сургуулийн төсвийг тооцож ХБГ-ийг Боловсролын яаманд тухай бүр танилцуулж байсан. Хавсралт: 1 файл		
11	Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх,	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	Ажлын чиг үүрэгт хамаарах чиглэлээр удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, мэдээ, судалгаа холбогдох заалтын биелэлтийг хугацаанд нь гаргаж удирдлагад хүргүүлэн ажилласан.	Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хугацаанд нь тайлагнасан байна.	Төрийн жинхэнэ албан хаагчийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлуулсан. 2025 оны 1-6 дугаар саруудад 75 албан бичиг ирсэн бүрэн шийдвэрлэж хариуг хүргүүлсэн. Явуулсан албан бичиг 6 байна. Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд биелүүлж ажиллаа. Үүнд: Судалгаа тайлан мэдээ бэлтгэх,	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					танилцуулга мэдээлэл бэлтгэх, шуурхай хурал, мэдээлэлд оролцох, орон нутаг хариуцсан мэргэжилтний ажлыг хавсран гүйцэтгэх хариуцан ажиллаж байсан.		
12	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	Албан ажлын гүйцэтгэлийн явцад цуглуулсан холбогдох тайлан, мэдээ, мэдээлэл болох нийт 32 боть баримт бичгийг ААХХ-ийн зааврын дагуу үдэж хавтаслан архивын нэгж бүрдүүлэн архивт хүлээлгэн өгсөн.	2024 оны албан ажлын гүйцэтгэлийн явцад цуглуулсан холбогдох тайлан, мэдээ, мэдээлэл, баримт бичгийг “Боловсролын ерөнхий газрын хөтлөх хэргийн жагсаалт”-ын дагуу архивын нэгж бүрдүүлэн архив, албан хэрэг хөтлөлтийн зааврын дагуу эмхэлж цэгцэлсэн байна.	2024 оны төрийн болон төрийн бус өмчийн сургуулийн төсөв санхүүгийн төлөвөлгөө, тайлан, санхүүжилт, ирсэн явсан албан бичиг баримт материалыг Боловсролын ерөнхий газрын хөтлөх хэргийн жагсаалт”-ын дагуу архивын хадгаламжийн нэгж болгон бүрдүүлж байна.	3-р сар, 6-р сар, 9-р сар	100%
13	Насантуршийн суралцахуйн төвийн төсвийн гүйцэтгэл, өрийн мэдээнд дүн шинжилгээ хийх, шаардлагатай төсвийн зохицуулалтыг хийж, батлагдсан төсвийн	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	2024 онд Насантуршийн суралцахуйн 29 төвд улсын төсвөөс гүйцэтгэлээр төсөв хуваарилж санхүүжүүлсэн.	НТСТ-ийн төсвийн гүйцэтгэл, өрийн мэдээнд дүн шинжилгээ хийж, батлагдсан төсвийн хүрээнд өр авлага үүсгэхгүй ажилласан байна.	Насантуршийн суралцахуйн төвийн 2025 оны төсвийг 2024 оны батлагдсан цалинг 6 хувь нэмэгдүүлэн хуваарилсан. Нийслэлд Багахангай дүүрэгт шинээр	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар,	100%

	хүрээнд өр авлага үүсгэхгүй ажиллах				Насантуршийн суралцахуйн төв ашиглалтад орж орон тооны гүйцэтгэлээр санхүүжилтийг тооцож олгосон. Сар бүр насантуршийн суралцахуйн төвөөс ирүүлсэн орлогын саналыг хүлээн авч төсөвт өөрчлөлт оруулж, санхүүжилтийг олгож байна. 2025 оны 1-6 дугаар сард улсын төсвөөс 6,242.9 сая төгрөгийн санхүүжилт, оны эхний үлдэгдлээс 3,647.8 сая төгрөг, үндсэн туслах үйл ажиллагааны орлогоос 277,8 сая төгрөг санхүүжүүлсэн. 2025 оны 6 дугаар сард оны эхний үлдэгдэл мөнгөн хөрөнгийн зарцуулах эрхийн нээж багш, ажилчдын ээлжийн амралт цалинг тооцож өр төлбөргүй ажиллаж байна. Хавсралт: 1 файл	9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	
--	--	--	--	--	---	--	--

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
			1	2	3	4	5
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Боловсролын төсвийн төлөвлөлтийг сайжруулах чиглэлээр туршлага судалж мэргэжлээ дээшлүүлэх,	Сургалтад хамрагдсан байна.	Мэдлэг, боловсрол дээшилсэн байна.	Сургалтад хамрагдсан байна.	Ховд, Өмнөговь, Сэлэнгэ аймгуудын боловсролын салбарын санхүүгийн албан хаагчдад төсөв санхүүгийн чиглэлээр сургалт зохион байгуулж, мөн боловсролын салбарын төсөв санхүү бодит байдалд хэрхэн хэрэгжиж байгаа тал дээр туршлага судалж цаашид ямар арга хэмжээ авч ажиллахыг дүгнэж ажилласан. Монгол улсын Засгийн газрын 2024 оны 39, 53 дугаар тогтоолын хэрэгжилт, Боловсролын сайдын шинэчилсэн А/279 дугаар зааварын танилцуулга мэдээллийг хүргүүлсэн. Төрийн албан хаагчдын цалин нэмэгдэл нэмэгдсэн холбоотой ЗГ-ын 39, 53 тогтоолд өөрчлөлт оруулах, ЕБС-ын орон тооны норматив шинэчлэн батлуулах, багш ажилчдын үр дүнгийн урамшуулал олгохыг хууль эрхзүйд тодорхой болгож тусгуулах, нэмэгдэл цалин хөлс "ур чадвар, ХАБ, ХБХ ажилласаны нэмэгдэл, унаа хоолны нөхөн төлбөр" зэрэг асуудлуудыг тодорхой болгохыг санхүүгийн албан хаагчид дүгнэж байна. Хавсралт: 1 файл	6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

2	Санхүүгийн мэргэжлийн сургалтын байгууллагаас зохион байгуулж буй сургалтуудад хамрагдах.	Сургалтад хамрагдсан байна.	Мэдлэг, боловсрол дээшилсэн байна.	Сургалтанд хамрагдсан байна.	Төсөв санхүүгийн мэргэжил, мэдлэгээ дээшлүүлэхээр Монгол улсын Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгээс зохион байгуулсан цахим болон танхим сургалтуудад хамрагдаж, ТМЗ-ын эрх олгох сорил болон үндсэн шалгалтуудад оролцохоор бэлтгэсэн. 2025 оны 5 дугаар сарын 22-23 өдрүүдэд сорил шалгалтанд хамрагдсан. Хавсралт: 1 файл	3-р сар, 6-р сар, 9-р сар, 12-р сар	100%
---	---	-----------------------------------	---	------------------------------------	---	---	------

ТАЙЛАН ГАРГАСАН:

Ерөнхий боловсролын салбарын төсвийн хэрэгжилт, зохицуулалт, санхүүжилт хариуцсан мэргэжилтэн / Улаанбаатар /, Оюунбилэг
Ууганчимэг /...../ Огноо: